

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БСШУСС	Боловсрол соёл шинжлэх ухаан спортын сайд
БСШУСЯ	Боловсрол соёл шинжлэх ухаан спортын яам
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Агуулга

<b>1.Аудитын гэрчилгээ</b> .....	3
<b>2.Аудитын тайлан</b> .....	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.12. Шилэн дансны мэдээлэл .....	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
<b>3.Менежментийн захидал</b> .....	11
<b>4.Аудит хийсэн санхүүгийн тайлан</b> .....	13
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	13
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	14
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	16
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	18
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	19
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	21
<b>5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....</b>	<b>18</b>



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ  
ТӨВИЙН ЗАХИРЛЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ Ж.ГАН-ЭРДЭНЭ ТАНАА

2020.02.24 № 06/594  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсролын үнэлгээний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Боловсролын үнэлгээний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Боловсролын үнэлгээний төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2. Аудитын тайлан

### 2.1. Оршил

БСШУСЯ-ны дэргэдэх Боловсролын үнэлгээний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Боловсролын үнэлгээний төвийн захирлын үүрэг гүйцэтгэгч Ж.Ган-Эрдэнэ Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн орлогыг бүрэн төвлөрүүлэх, батлагдсан төсөвт багтаан зарцуулах, зарлага, авлагын үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулах сайжруулах системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсролын үнэлгээний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

БСШУСЯ-ны дэргэдэх Боловсролын үнэлгээний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 1 дүгээр сарын 27-ноос 2020 оны 2 дугаар сарын 7-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн Санхүүгийн аудитын газрын аудитор С.Отгонхорлоо хариуцаж хэрэгжүүлэв.

БСШУСЯ-ны дэргэдэх Боловсролын үнэлгээний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 01/10 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

БСШУСЯ-ны дэргэдэх Боловсролын үнэлгээний төвийн үйл ажиллагааны эрхэм зорилгоо үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, бүх шатны боловсролын үйлчилгээний чанарын баталгааг хангахад дэмжлэг үзүүлэхэд оршино гэж тодорхойлжээ.

Дээрх зорилгын хүрээнд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй бүх шатны сургалтын байгууллагын сургалтын чанарыг үнэлэх шалгуур үзүүлэлтийг олон улсын жишиг арга зүй, аргачлалаар боловсруулах, чанарын хяналт-шинжилгээ хийх, санал, дүгнэлт гаргах;
- Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын мэдлэг, чадвар, дадлыг үнэлэх үнэлгээний даалгавар боловсруулах, гүйцэтгэлийг үнэлэх арга зүйд багш нарыг сургах, хичээл бүрээр үнэлгээний жишиг даалгавар боловсруулах, суурь, бүрэн дунд боловсролын улсын шалгалт болон элсэлтийн ерөнхий шалгалтын даалгавар боловсруулах, даалгаврын сан бүрдүүлэх;
- Боловсролын чанарын үнэлгээний асуудлаар мэдээллийн сан үүсгэх, байгууллага, иргэдийг мэдээллээр хангах, үнэлгээний онол-арга зүйн чиглэлээр хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, мэргэжлийн байгууллагуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг дараах хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн албаны тухай хууль;
- “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” 2019 оны Засгийн газрын 276 тогтоол;
- “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 2019 оны Засгийн газрын 24 дүгээр тогтоол;
- “Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм батлах тухай” 2019 оны Засгийн газрын 33 дугаар тогтоол;

#### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Боловсролын үнэлгээний төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

БСШУСЯ-ны дэргэдэх Боловсролын үнэлгээний төв нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа “Acoulous” программ хангамж ашигладаг байна.

БСШУСЯ-ны дэргэдэх Боловсролын үнэлгээний төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.



## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар БСШУСЯ-ны дэргэдэх Боловсролын үнэлгээний төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 9 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

БСШУСЯ-ны дэргэдэх Боловсролын үнэлгээний төвийн төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 4,041,758.8 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 40,417.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг өөрчлөгдөөгүй болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

БСШУСЯ-ны дэргэдэх Боловсролын үнэлгээний төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,838,006.8 мянган төгрөгөөр буюу 187.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	5,935.6	1,130,518.5	1,124,582.9
Бараа материал	67,802.4	102,627.7	34,825.3
Үндсэн хөрөнгө	904,980.8	1,583,579.4	678,598.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>978,718.8</b>	<b>2,816,725.6</b>	<b>1,838,006.8</b>
Өр төлбөр	308.0	0.0	(308.0)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	978,410.9	2,816,725.6	1,838,314.7
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>978,718.8</b>	<b>2,816,725.6</b>	<b>1,838,006.8</b>

Өмнөх оны үзүүлэлтээс авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данснуудад материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Авлага дансны үлдэгдэл 1,124,582.9 мянган төгрөгөөр өссөн нь нэмэлт санхүүжилтийн дансанд Дэлхийн банкнаас санхүүжих төсөл хөтөлбөрийн 2018, 2019 оны санхүүжилтийн тайлант хугацаанд зарцуулагдаагүй үлдэгдлийг Сангийн яаманд төвлөрүүлж татаас санхүүжилтийн авлагаар бүртгэснээс шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 2014-2019 онуудад үүссэн, 2014 оны үүссэн хувь хүнээс авах 5,627.6 мянган төгрөгийн авлага байна. Үүнээс Эзэн холбогдогч нь тодорхойгүй байгаа шалтгааны улмаас барагдах боломжгүй, эрсдэлтэй 1,779.0 мянган төгрөгийн авлага байна.



Бараа материалын дансны үлдэгдэл 34,825.3 мянган төгрөгөөр өссөн нь Дэлхийн банк болон азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжих төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөс бичиг хэргийн, тусгай зориулалтын, бусад хангамжийн материал, шатахуун бэлтгэснээс шалтгаалжээ. Элсэлтийн ерөнхий шалгалт, монгол хэлбичгийн шалгалт, улсын шалгалт, чанарын үнэлгээний шалгалтад зориулж оны эцэст 507,904.7 мянган төгрөгийн 365 нэр төрлийн материалын худалдан авалт хийж нөөц үүсгэсэн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 678,598.6 мянган төгрөгөөр өссөн нь Элсэлтийн ерөнхий шалгалтад зориулж 65,350.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж бэлтгэж, хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан 1,077,777.3 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

## 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Боловсролын үнэлгээний төв нь тайлант онд үндсэн үйл ажиллагааны орлогоос /элсэлтийн шалгалтын орлого/ 421,500.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 346,582.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөө 74,917.9 мянган төгрөг буюу 17.8 хувиар тасарсан байна.

БСШУСЯ-ны дэргэдэх Боловсролын үнэлгээний төвийн орлого 74,917.9 мянган төгрөгөөр тасарсан нь 2019 оны 1 дүгээр сарын 30-ны БСШУСС-ын А/42 дугаар тушаалаар заавал авах монгол хэлбичгийн шалгалтын босго оноог 400 байхаар тогтоосон, шалгалт өгөх хүүхдийн тоо цөөрсөн зэргээс шалтгаалсан байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 1,882,449.9 мянган төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,639,142.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 346,582.1 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,564,224.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 346,582.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж 1,868,449.9 мянган төгрөгийг зарцуулж 42,356.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,868,449.9 мянган төгрөг буюу 94.1 хувьтай байгаа нь Мэдээллийн маягт хэвлэх бэлтгэх зардал 77,184.2 мянга, томилолт 7,276.8 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 5,825.4 мянга, шуудан холбооны зардлын төсвийг 1,122.5 мянган төгрөг дутуу зарцуулснаас шалтгаалсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

**Нэмэлт төсөв:** БСШУСЯ-ны дээд шатны төсвийн захирагчаас Чанарын үнэлгээний төслийн үйл ажиллагааны зардал 226,975.4 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого ХНХЯ болон Боловсролын чанар, Дээд боловсролын чанарын шинэчлэл, Бага боловсрол зэрэг төсөл хөтөлбөрөөс 1,539,278.2 мянга, нийт 1,766,253.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс 634,987.9 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж, үлдэгдэл 1,131,265.7 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

## **2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд 4, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэлтэй асуудлыг тодорхойлж нийт 9 горим, сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 94,870.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 3,287.2 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 91,583.3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө. Үүнээс

Улсын төсөвт шууд төвлөрүүлэх үндсэн үйл ажиллагааны орлогыг арилжааны банкуудтай хийсэн гэрээний дагуу орсон орлогын нэг хувьтай тэнцэх шимтгэлийн дүнгээр 3,287.1 мянган төгрөгөөр орлого бууруулан бүртгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Сангийн сайд, Монголбанкны ерөнхийлөгчийн 2013 оны 24/24/А-9 дугаар хамтарсан "Засгийн газрын болон төсвийн байгууллагын дансыг монголбанк болон банканд нээх, хаах журам"-ын "Тэг үлдэгдэлтэй данс"ны журмыг тус тус мөрдөж ажиллах.

### Шийдвэрлэсэн нь:

Гэрээг шинэчлэн байгуулах, орлого бууруулах бичилт хийхгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

Аудитаар илэрсэн 91,583.3 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## **2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Дараагийн аудитаар анхаарал татахуйц авч үзэх асуудал гараагүй.

## **2.13. Шилэн дансны мэдээлэл**

БСШУСЯ-ны дэргэдэх Боловсролын үнэлгээний төв нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Байгууллагын цахим хуудас [www.eec.mn](http://www.eec.mn) шилэн дансны сайтад байгууллагын тухайн жилийн төсөв, гүйцэтгэл, цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, санхүүжилт, бараа, ажил үйлчилгээ, ажил үйлчилгээний тушаалууд, худалдан авах ажиллагааны холбогдох 202 мэдээллүүдийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

## **2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 4 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

## **2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид БСШУСЯ-ны дэргэдэх Боловсролын үнэлгээний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Боловсролын үнэлгээний төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг САГ-2020/2/СТА-ТШЗ

холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### 3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 1. Орлогын данстай холбоотой асуудал

##### 1.1. Илрүүлэлт:

Үндсэн үйл ажиллагааны орлогыг батлагдсан төсвөөс 74,918.0 мянган төгрөгөөр буюу 17.8 хувиар дутуу бүрдүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэснийг мөрдөж ажиллах.

##### 1.2. Эрсдэл:

Орлогыг бүрэн төвлөрүүлээгүй, холбогдох хууль журам зааврыг хэрэгжүүлж ажиллаагүй байх;

##### 1.3. Өгсөн зөвлөмж:

Өөрийн үйл ажиллагааны орлогыг бодитой төлөвлөж, бүрэн төвлөрүүлэх;

##### 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

#### 2. Авлагын данстай холбоотой асуудал

##### 2.1. Илрүүлэлт:

а.2014 онд үүссэн хувь хүмүүсээс авах 5,627.6 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, барагдуулаагүй байна.

б.Цалингаас тооцох НДШ-ийн тооцооллыг буруу хийснээс 1,671.3 мянган төгрөгийн илүү төлж, авлага үүссэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэснийг зөрчсөн байна.

**2.2. Эрсдэл:**

Авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байх, батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргаагүй байх, төсөв хэтрэх;

**2.3. Өгсөн зөвлөмж:**

Төсвийг зохистой удирдаж өр авлага үүсгэхгүй байх, авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах, барагдуулж ажиллах;

**2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

**3. Зардлын данстай холбоотой асуудал**

**3.1. Илрүүлэлт:**

Ажилтанд цалингийн сангаас Шүүхийн шийдвэрийн дагуу ажилгүй байсан хугацааны цалин, нийгмийн даатгалын шимтгэлд өгсөн байна.

**3.2. Эрсдэл:**

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байх, төсөв хэтрэх;

**3.3. Өгсөн зөвлөмж:**

Холбогдох эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлэх, албан тушаалтнаар нөхөн төлүүлж зөрчлийг арилгах арга хэмжээ авах;

**3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4.Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>73,738,091.66</b>	<b>1,233,146,227.02</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>5,935,685.00</b>	<b>1,130,518,510.36</b>
33300	Татаас, санхүүжилтийн авлага	308,000.00	1,123,219,523.93
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	<b>5,627,685.00</b>	<b>7,298,986.43</b>
3351	Байгууллагаас авах авлага	-	1,671,301.43
3352	Хувь хүмүүсээс авах авлага	5,627,685.00	5,627,685.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>67,802,406.66</b>	<b>102,627,716.66</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>17,381,800.00</b>	<b>17,381,800.00</b>
35110	Тусгай зориулалттай материал	17,381,800.00	17,381,800.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>50,420,606.66</b>	<b>85,245,916.66</b>
35410	Бичиг хэргийн материал	13,904,106.66	24,400,316.66
35420	Аж ахуйн материал	15,305,000.00	15,478,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,133,600.00	2,484,000.00
35470	Бусад хангамжийн материал	20,077,900.00	42,883,600.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>904,980,760.14</b>	<b>1,583,579,360.23</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>904,980,760.14</b>	<b>1,583,579,360.23</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>810,659,856.33</b>	<b>1,536,376,526.58</b>
39203	Авто-тээврийн хэрэгсэл	65,629,400.00	65,629,400.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(65,629,400.00)	(65,629,400.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,344,756,946.00	2,430,672,094.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(619,956,595.80)	(1,008,457,146.76)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	93,438,560.33	99,300,760.33
39208	Хуримтлагдсан элэгдэл	(7,579,054.20)	(18,957,930.96)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,534,840.00	52,884,840.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,534,840.00)	(19,066,090.03)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>94,320,903.81</b>	<b>47,202,833.65</b>
39301	Програм хангамж	296,324,560.00	296,324,560.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(202,003,656.19)	(249,121,726.35)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>978,718,851.80</b>	<b>2,816,725,587.25</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>308,000.00</b>	<b>00.26</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>308,000.00</b>	<b>00.26</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>308,000.00</b>	<b>00.26</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	00.26
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	<b>308,000.00</b>	<b>-</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	308,000.00	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>978,410,851.80</b>	<b>2,816,725,586.99</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>978,410,851.80</b>	<b>2,816,725,586.99</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	344,839,013.00	344,839,013.00
51101	Өмч:-төрийн	344,839,013.00	344,839,013.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>633,413,654.37</b>	<b>2,471,728,389.56</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	633,413,654.37	633,413,654.37
51220	Тайлант үеийн үр дүн	-	1,838,314,735.19
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	158,184.43	158,184.43
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>978,718,851.80</b>	<b>2,816,725,587.25</b>

## 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,377,115,563.87</b>	<b>4,759,574,047.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,130,910,193.87</b>	<b>1,429,096,057.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,130,910,193.87	1,429,096,057.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,114,867,193.87	1,427,079,417.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	848,559,497.87	346,582,069.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	2,720,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого ҮХ	-	1,077,777,348.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого БМ	-	2,016,640.00
120009	Бусад орлого	16,043,000.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,246,205,370.00</b>	<b>3,330,477,990.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,130,113,100.00</b>	<b>1,564,224,400.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,130,113,100.00	1,564,224,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>116,092,270.00</b>	<b>1,766,253,590.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	116,092,270.00	226,975,360.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,539,278,230.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,323,191,080.25</b>	<b>2,921,259,311.81</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,323,191,080.25</b>	<b>2,921,259,311.81</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,241,999,903.03</b>	<b>2,869,656,530.25</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>553,812,699.00</b>	<b>902,585,031.69</b>
210101	Үндсэн цалин	478,140,215.00	504,518,669.00
210102	Нэмэгдэл	-	145,015.00
210105	Гэрээт ажлын хөлс	75,672,484.00	397,921,347.69
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>65,865,280.26</b>	<b>111,919,816.88</b>
210201	Тэтгэврийн даатгал	47,315,208.80	91,902,454.68
210202	Тэтгэмжийн даатгал	3,663,663.03	5,066,740.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,141,839.05	3,986,831.44
210204	Ажилгүйдлийн даатгал	647,434.18	996,709.36
210205	Эрүүл мэндийн даатгал	10,097,135.20	9,967,080.60
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>91,800,000.00</b>	<b>91,800,000.00</b>
210304	Байрны түрээс	91,800,000.00	91,800,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>55,198,474.00</b>	<b>101,888,659.45</b>
210401	Бичиг хэрэг	19,513,380.67	73,129,190.00
210402	Тээвэр, шатахуун	6,917,100.00	15,499,527.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,591,583.33	7,770,442.45
210404	Ном, хэвлэл	18,000,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,176,410.00	5,489,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,550,350.00</b>	<b>-</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	140,000.00	-
210604	Урсгал засвар	1,410,350.00	-
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>26,100,980.00</b>	<b>40,091,840.00</b>
210701	Гадаад албан томилолт	2,620,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	23,480,980.00	40,091,840.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>160,476,390.86</b>	<b>80,543,163.08</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,755,990.86	60,444,029.08
210803	Даатгалын үйлчилгээ	2,475,000.00	2,474,934.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	197,500.00	177,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,161,000.00	1,781,400.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	134,886,900.00	15,665,800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,287,195,728.91</b>	<b>1,540,828,019.15</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	975,481,074.87	1,076,299,271.24
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	311,714,654.04	464,528,747.91
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>81,191,177.22</b>	<b>51,602,781.56</b>



**БСШУСЯамны дэргэдэх Боловсролын үнэлгээний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	1,200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,200,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	81,191,177.22	50,402,781.56
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	81,191,177.22	42,356,563.06
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	8,046,218.50
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>53,924,483.62</b>	<b>1,838,314,735.19</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	191,370,215.85	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	191,370,215.85	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(191,370,215.85)	-
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(137,445,732.23)</b>	<b>1,838,314,735.19</b>

### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>2,111,265,867.87</b>	<b>3,679,780,059.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>865,060,497.87</b>	<b>349,302,069.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	865,060,497.87	349,302,069.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	848,709,497.87	349,302,069.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	848,709,497.87	346,582,069.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	2,720,000.00
120009	Бусад орлого	16,351,000.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,246,205,370.00</b>	<b>3,330,477,990.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,130,113,100.00	1,564,224,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,130,113,100.00	1,564,224,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	116,092,270.00	1,766,253,590.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	116,092,270.00	226,975,360.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,539,278,230.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>2,003,340,867.87</b>	<b>3,614,430,059.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,003,340,867.87</b>	<b>3,614,430,059.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,922,149,690.65</b>	<b>2,439,607,753.51</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	553,812,699.00	731,490,007.81
210101	Үндсэн цалин	351,899,945.66	226,854,800.00
210102	Нэмэгдэл	106,422,369.34	74,453,960.12
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,817,900.00	31,259,900.00
210104	Урамшуулал	1,000,000.00	1,000,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	75,672,484.00	397,921,347.69
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	66,345,680.26	89,284,031.11
210201	Тэтгэврийн даатгал	65,285,680.26	77,193,162.88
210202	Тэтгэмжийн даатгал	-	3,336,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	2,224,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	414,568.88
210205	Эрүүл мэндийн даатгал	1,060,000.00	6,115,999.35
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	91,800,000.00	91,800,000.00
210304	Байрны түрээс	91,800,000.00	91,800,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	56,494,533.33	96,569,229.45
210401	Бичиг хэрэг	20,809,440.00	68,173,000.00
210402	Тээвэр, шатахуун	6,917,100.00	14,833,287.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,591,583.33	7,770,442.45
210404	Ном, хэвлэл	18,000,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,176,410.00	5,792,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,625,350.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	215,000.00	-
210604	Урсгал засвар	1,410,350.00	-
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	26,100,980.00	40,091,840.00
210701	Гадаад албан томилолт	2,620,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	23,480,980.00	40,091,840.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	159,845,990.86	286,623,972.47
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,125,590.86	254,174,838.47
210803	Даатгалын үйлчилгээ	2,475,000.00	2,474,934.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	197,500.00	177,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,161,000.00	1,781,400.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	134,886,900.00	28,015,800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	966,124,457.20	1,103,748,672.67

**БСШУСЯамны дэргэдэх Боловсролын үнэлгээний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	966,124,457.20	1,103,748,672.67
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>81,191,177.22</b>	<b>1,174,822,305.49</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	1,200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,200,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	1,173,622,305.49
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	42,356,563.06
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,131,265,742.43
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	81,191,177.22	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	81,191,177.22	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>107,925,000.00</b>	<b>65,350,000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>107,925,000.00</b>	<b>65,350,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>107,925,000.00</b>	<b>65,350,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	107,925,000.00	65,350,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	107,925,000.00	65,350,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(107,925,000.00)</b>	<b>(65,350,000.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	-
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	344,839,013.00	158,184.43	591,363,648.63	936,360,846.06
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>344,839,013.00</b>	<b>158,184.43</b>	<b>591,363,648.63</b>	936,360,846.06
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	105,385,061.73	105,385,061.73
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>344,839,013.00</b>	<b>158,184.43</b>	<b>633,413,654.37</b>	978,410,851.80
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>344,839,013.00</b>	<b>158,184.43</b>	<b>633,413,654.37</b>	978,410,851.80
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>344,839,013.00</b>	<b>158,184.43</b>	<b>633,413,654.37</b>	978,410,851.80
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	00.00	-	1,838,314,735.19	1,838,314,735.19
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>344,839,013.00</b>	<b>158,184.43</b>	<b>2,471,728,389.56</b>	<b>2,816,725,586.99</b>

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,985,724,400.00	1,868,449,905.94	117,274,494.06	94.1
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,985,724,400.00	1,868,449,905.94	117,274,494.06	94.1
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,984,524,400.00	1,867,249,905.94	117,274,494.06	94.1
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	333,622,900.00	333,568,660.12	54,239.88	100.0
210101	Үндсэн цалин	226,854,800.00	226,854,800.00	-	100.0
210102	Нэмэгдэл	74,508,200.00	74,453,960.12	54,239.88	99.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,259,900.00	31,259,900.00	-	100.0
210104	Урамшуулал	1,000,000.00	1,000,000.00	-	100.0
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	41,703,000.00	40,448,868.23	1,254,131.77	97.0
210201	Тэтгэврийн даатгал	28,358,000.00	28,358,000.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	3,336,300.00	3,336,300.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,668,900.00	2,224,000.00	444,900.00	83.3
210204	Ажилгүйдлийн даатгал	667,300.00	414,568.88	252,731.12	62.1
210205	Эрүүл мэндийн даатгал	6,672,500.00	6,115,999.35	556,500.65	91.7
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	91,800,000.00	91,800,000.00	-	100.0
210304	Байрны түрээс	91,800,000.00	91,800,000.00	-	100.0
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	38,853,900.00	37,710,242.45	1,143,657.55	97.1
210401	Бичиг хэрэг	13,000,000.00	12,980,000.00	20,000.00	99.8
210402	Тээвэр, шатахуун	11,288,500.00	11,287,300.00	1,200.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,772,900.00	7,650,442.45	1,122,457.55	87.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,792,500.00	5,792,500.00	-	100.0
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	14,000,000.00	14,000,000.00	-	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,137,800.00	8,137,800.00	-	100.0
210602	Тавилга	5,862,200.00	5,862,200.00	-	100.0
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	25,000,000.00	17,723,240.00	7,276,760.00	70.9
210702	Дотоод албан томилолт	25,000,000.00	17,723,240.00	7,276,760.00	70.9
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	331,086,500.00	248,076,822.47	83,009,677.53	74.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	221,453,100.00	215,627,688.47	5,825,411.53	97.4
210803	Даатгалын үйлчилгээ	2,475,000.00	2,474,934.00	66.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	177,000.00	177,000.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,781,400.00	1,781,400.00	-	100.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	105,200,000.00	28,015,800.00	77,184,200.00	26.6
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1108458100.00	1083922072.67	24,536,027.33	97.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,108,458,100.00	1,083,922,072.67	24,536,027.33	97.8
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1200000.00	1200000.00	-	100.0
2131	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	-	-	-	-
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,200,000.00	1,200,000.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,200,000.00	1,200,000.00	-	100.0

**БСШУСЯамны дэргэдэх Боловсролын үнэлгээний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,985,724,400.00	1,868,449,905.94	117,274,494.06	94.1
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,564,224,400.00	1,521,867,836.94	42,356,563.06	97.3
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,564,224,400.00	1,521,867,836.94	42,356,563.06	97.3
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	421,500,000.00	346,582,069.00	74,917,931.00	82.2
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	421,500,000.00	346,582,069.00	74,917,931.00	82.2
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	24	36	-12	
620001	Удирдах ажилтан	1	1	0	
620002	Гүйцэтгэх ажилтан	23	35	-12	
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>24</b>	<b>38</b>	-14	
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	24	36	-12	

#### 4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>1,766,253,590.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>1,766,253,590.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	634,987,847.57
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	-	397,921,347.69
210105	Гэрээт ажлын хөлс	-	397,921,347.69
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	-	48,835,162.88
210201	Тэтгэврийн даатгал	-	48,835,162.88
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	63,458,987.00
210401	Бичиг хэрэг	-	59,793,000.00
210402	Тээвэр, шатахуун	-	3,545,987.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	120,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	22,368,600.00
210702	Дотоод албан томилолт	-	22,368,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	35,827,150.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	35,827,150.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	66,576,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	66,576,600.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	<b>1,131,265,742.43</b>
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,131,265,742.43
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>1,766,253,590.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	<b>1,766,253,590.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	226,975,360.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,539,278,230.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	-	<b>-</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-



5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Аудитын тайлангийн хавсралт

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

<b>Огноо:</b>	<b>2019 он</b>	<b>Аудитын нэр:</b>	<b>Санхүүгийн тайлангийн аудит</b>	<b>САГ-2020/2/СТА-ТШЗ</b>
<b>Шалгагдсан</b>	<b>Боловсролын үнэлгээний төв</b>		<b>мянган төгрөгөөр</b>	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /мянган төгрөгөөр/	Аудитын байгууллага ас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
<b>A</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>5</b>
1	Үндсэн үйл ажиллагааны орлогыг батлагдсан төсвөөс 74,918.0 мянган төгрөгөөр буюу 17.8 хувиар дутуу бүрдүүлсэн байна.	74,918.0	Зөвлөмж өгөх	Боловсролын үнэлгээний төвийн захирлын үүрэг гүйцэтгэгч, Нягтлан бодогч	Ж.Ган-Эрдэнэ, Н.Шинэбаяр
2	2014 онд үүссэн хувь хүмүүсээс авах 5,627.6 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, барагдуулаагүй байна.	5,627.6	Зөвлөмж өгөх	Боловсролын үнэлгээний төвийн захирлын үүрэг гүйцэтгэгч, Нягтлан бодогч	Ж.Ган-Эрдэнэ, Н.Шинэбаяр
3	Цалингаас тооцох НДШ-ийн тооцооллыг буруу хийснээс 1,671.3 мянган төгрөгийн илүү төлж, авлага үүссэн байна	1,671.3	Зөвлөмж өгөх	Боловсролын үнэлгээний төвийн захирлын үүрэг гүйцэтгэгч, Нягтлан бодогч	Ж.Ган-Эрдэнэ, Н.Шинэбаяр
3	Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэрээс гарсан ажиллаагүй хугацааны цалинг нөхөн олгоходоо цалингаас 9,366.4 мянган төгрөгийг өгсөн байна.	9,366.4	Зөвлөмж өгөх	Боловсролын үнэлгээний төвийн захирлын үүрэг гүйцэтгэгч, Нягтлан бодогч	Ж.Ган-Эрдэнэ, Н.Шинэбаяр
4	Улсын төсөвт шууд төвлөрүүлэх үндсэн үйл ажиллагааны орлогыг арилжааны банкуудтай хийсэн гэрээний дагуу орсон орлогын нэг хувьтай тэнцэх шимтгэлийн дүнгээр орлого бууруулан бүртгэж байна.	3,287.2	Албан шаардлага хүргүүлэх	Боловсролын үнэлгээний төвийн захирлын үүрэг гүйцэтгэгч, Нягтлан бодогч	Ж.Ган-Эрдэнэ, Н.Шинэбаяр
<b>Дүн</b>		<b>94,870.5</b>			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 03 № 01/65  
САГ- 2020/2/СТХ-Тээ3

Улаанбаатар хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсролын үнэлгээний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Улсын төсөвт шууд төвлөрүүлэх үндсэн үйл ажиллагааны орлогыг арилжааны банкнуудтай хийсэн гэрээний дагуу орсон орлогын нэг хувьтай тэнцэх шимтгэлийн дүнгээр орлого бууруулан бүртгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Сангийн сайд, Монголбанкны ерөнхийлөгчийн 2013 оны 24/24/А-9 дугаар хамтарсан "Засгийн газрын болон төсвийн байгууллагын дансыг Монголбанк болон банканд нээх, хаах журам"-ын "Тэг үлдэгдэлтэй данс"ны журмыг тус тус мөрдөж ажиллах.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах акт тавих, зөрчлийг арилгах албан шаардлага өгөх..." Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үндсэн үйл ажиллагааны орлогыг арилжааны банканд орсон тухай бүрд бүрэн төвлөрүүлж байх, орлого бууруулах бичилт хийхгүй байх.
2. Албан шаардлагыг биелэлтийг 2020 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Боловсролын үнэлгээний төвийн захирлын үүрэг гүйцэтгэгч Ж.Ган-Эрдэнэ, нягтлан бодогч Н.Шинэбаяр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ:

**ӨГСӨН:**  
САГ-ЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР   
Ц.НАРАНЧИМЭГ  
АУДИТОР   
С.ОТГОНХОРЛОО

**ЗӨВШӨӨРСӨН:**  
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВИЙН  
ЗАХИРЛЫН ҮҮВЭГ ГҮЙЦЭТГЭГЧ  
УНЭЛГЭЭНИЙ  
НЯГТЛАН БОДОГЧ Ж.ГАН-ЭРДЭНЭ  
ТБАГУТУГ  
Н.ШИНЭБАЯР

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь салгах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу харууцагч албан тушаалтанд харууцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10.20\Richie\_Kheree\Alban Shaardlaga\2020\0303SAGS.Docx

001080197